

МОНГОЛ ХЭЛНЭЭ ШУУД ТУСАГДАХУУНЫГ ЗААХЫН ТИЙН ЯЛГАЛЫН
НӨХЦӨЛӨӨР ОНЦЛОН ЯЛГАЖ ЗААХ ЁС

Б.Пүрэвсүрэн¹

Олон хэлний хэвшинжийн судлал болон хэлний нийтлэгийн судлалд аливаа хэлэнд нэр үг болон нэрийн бүлгийн тоо, хүйс, амьтай/амьгүй болон тодорхой/тодорхой бусыг ялган заах үгийн сангийн нэгж, хэлзүйн бүтээвэр бий эсэхээр нь ангилна. Хүн аливаа хүн, юм, үзэгдэл, хийсвэр ойлголтын талаар өгүүлэхдээ уг зүйлийнхээ ерөнхий шинж байдлыг нь хэлээд өнгөрөх зэргээр ижил төрлийн нь олноос тухайлж, ялгалгүй хэлэх эсвээс тодорхой нэг зүйлийг онцлон ялгаж, тухайлан хэлж болно.

(1) *Яваад нэг тайлбар толь аваад ир. Энэ үгийг хэрхэн бичдэгийг үзье.*

(2) *Нөгөө тайлбар толио аваад ирээч. Энэ үгийн утгыг дахин лавлаж үзье.*

Эхний өгүүлбэр (1) монгол хэлний тайлбар тольд хамаарах, үгийн бичлэгийг лавлан үзэх хэдэн ч толь бичиг байж болохоос нэгийг нь олж ирэх тухай болно. Харин дараагийн өгүүлбэр (2)-т урьд өмнө нь хэрэглэж байсан тодорхой нэгэн хэрэглэхүүний тухай өгүүлсэн болно. Эдгээр өгүүлбэрт өгүүлсэн толь бичиг **тодорхой** эсвэл **тодорхой бус** болох нь ярианы орчин, нөхцөл байдал буюу хам сэдвээс хамааран “нэг”, “нөгөө”² гэсэн үгээр тус тус илэрч байна.

Референтийг тухайлж/тодорхой хэлэх, эс тухайлж/тодорхой бус хэлэх нь хам сэдвээс гадна өгүүлэгч нь сонсогчоо ямар толь бичиг болохыг мэдэх эсвэл мэдэхгүй гэдгийг хэрхэн үнэлж байгаагаас хамаарна.

(3) *Номын санд очоод монгол хэлний тайлбар толь аваад ир.* гэсэн өгүүлбэрт “монгол хэлний тайлбар толь” гэдэг референт³ нь тодорхой толь бичиг эсвэл ямар ч байж болох тодорхойгүй нэгэн толь бичиг байж болох ба

i. өгүүлэгч, сонсогч аль аль нь монгол хэлний бүх тайлбар толь бичгээс эсвэл тодорхой нэгэн орон зайд байгаа толь бичгээс зохиогч, хэвлэсэн он, толгой үгийн тоо, хуудасны тоо зэрэг шинжээр нь чухам аль нь болохыг мэдэж байгаа, эсвэл.

ii. өгүүлэгч болон сонсогчийн аль нэг нь мэдэж байгаа, харин нөгөө нь ямар тайлбар толь

1. Монгол Улсын Их Сургууль

2. Заах төлөөний нэр тухайн нэрийн бүлгийн тодорхой, тодорхой бусыг заадаг болохыг “...франц хэлний тодорхойгүй утга илэрхийлдэг (un/une) ялгац үгийг монгол хэлний “нэг” гэдэг үгээр илэрхийлж болно” гэж 1897 онд Францад гарсан Монгол хэлзүй номд тэмдэглэснийг проф. Ц. Шагдарсүрэн (2010:45) дурдаад “...монгол хэлний “нэг”, “хоёр” зэрэг тооны үг нь тодорхойгүй утга, “нөгөө[хи]”, “мөнөө[хи]”, “тэр” гэх зэрэг төлөөний үг тодорхой утга илэрхийлэх ялгацын үүргийг давхар гүйцэтгэдэг” гэжээ.

3. Оногдохуй хэмээн монголчилсон байдаг. Утгын сонгодог онолоор тэмдэглэгдэхүүн болно.

Б.Пүрэвсүрэн

болохыг тухайлж мэдэхгүй зөвхөн хоёр хэлний толь, зурагт тайлбар толь зэргээс ялгаатай толь бичиг байх ёстой гэсэн төдий өргөн утгаар хэлж/хүлээж авч болох төдийгүй.

iii. өгүүлэгч, сонсогч аль аль нь тухайлж мэдэхгүй монгол хэлний ямар нэгэн тайлбар толь хайж олох тухай хэлсэн байж болно.

Энэ мэт олон хувилбар утгаар хэлэх-хүлээж авах, түүний цаад учир шалтгаан, нөгөө талаас шалтгаан бүрийг тодорхойн ай⁴ гэсэн хүрээнд хэлний үзэгдэл болохыг дискурсын хүчин зүйлтэй холбон судлахын сацуу хэлшинжлэлийн утгазүй болон хэлний нэгжийн аж хэрэглээний ай (semantic and pragmatic category), хэлний нэгжийн үүргийн ай (functional category) болох тухай үүднээс олон талт судлал хөгжиж иржээ.

Хүн төрөлхтний олон хэлний тогтолцоо харилцан адилгүй, хэлний нэгжийн хэрэглээ өвөрмөц онцлогтой байдаг ч олон хэлний хэлзүйн байгуулалд тодорхой/тодорхой бусын ай түгээмэл илэрдэг байна. Энэ нь сэтгэхүйн үйлийн нэгээхэн хэсэг бөгөөд хүний уураг тархинд хэл яриа үүсэхэд хоёр өөр загвараар бий болдог ажээ. Тухайлсан, эс тухайлсан хоёр загварыг ялгаж илэрхийлэх нь хүний хийсвэрлэн бодох үйл ажиллагааны нэгээхэн үйлдэл бөгөөд нийт хүн төрөлхтний хэл ярианд нийтлэг, зарчимаар илэрдэг. Харин хэлний хэрэглүүрээр илэрхийлэх арга, хэлбэрээр нь хэл хэлэнд өвөрмөц байна.

Зарим хэлэнд өгүүлбэрийн нэрийн бүлгээр илэрсэн гишүүн тухайн өгүүлбэр хийгээд түүгээр зогсохгүй тухайн контекстийн хүрээнд урьд дурьдагдсан, тодорхой, өгүүлэгч болон сонсогчид танил эсэхийг заах үүрэг бүхий үгийн сангийн нэгж (ялгац, сэдэв заагч) байдаг бол нөгөө зарим хэлэнд нэр үг, нэрийн бүлгийн өгүүлбэрийн бусад гишүүнтэй холбогдох харьцааг заах үүрэг бүхий бүтээврээр илэрхийлдэг. Ийм үгийн сангийн тусгай нэгж болон бүтээвэртэй бол хэлзүйн тодорхойн ай (grammatical category)-тай⁵ гэж үзнэ. Мөн ялгацын утга ялгах үүргийг авназүй, үгзүй, өгүүлбэрзүйн аргаар буюу өгүүлбэрийн гишүүдийн байрлал, дарааллаар илэрхийлдэг арга, тогтолцоо бүхий хэл байх ба хүмүүний олон хэлэнд үгийн сангийн болон хэлзүйн аргаар илэрхийлэх нь нэлээд түгээмэл байдаг байна.

Хэлний нэгжийн хэлбэр, утга, үүргийн судлалд өгүүлбэрийн аль ч гишүүний үүргээр орсон нэрийн бүлэгт тодорхойн айн судлалд авч үздэг бол өгүүлбэрийн шууд тусагдахууныг онцлон, ялган заасан эсэхийг ялгах ёс (specificity in NP) гэсэн дэд ай болгон судална. “нэгэн ном” гэсэн нэрийн бүлэг онцлон ялгасан (specific), онцлон ялгаагүй (non-specific) тодорхой бус референттэй болохыг (4) болон (5) жишээнээс харж болно.

(4) *Би нэг толь бичиг хайж явна, хаана тавьснаа санадаггүй.*

(5) *Би нэг толь бичиг хайж явна, энэ хавьд номын дэлгүүр бий юү?*

Шууд тусагдахууныг өгүүлбэрт бүтээврээр ялган заахыг (DOM - differentiated object marking) гэх бөгөөд заахын тийн ялгалын нөхцлөөр илрэх нь түрэг хэлнүүдэд байх онцлог болохыг хэлзүй, утгазүйн талаас судалсан олон бүтээл байдаг. Олон хэлний хэв шинжийн судлалд шууд тусагдахууныг ялган заах эсэх нь:

(i) амьтай амьгүйн айг ялган заах,

(ii) референтийг ялган заах,

(iii) мэдээллийн бүтэцтэй холбоотой топик буюу сэдэвийг ялган заах (topicality)

гэсэн дараах 3 параметрээс хамаарах нь нийтлэг болохыг тогтоосон байна.

4. Christopher Lyons. Definiteness, 1999.

5. William Croft. 1990:27, Christopher Lyons, 1999:253.

Б.Пүрэвсүрэн

Эдгээрээс референтийг онцлон ялгах нь нэлээд онцлог хийгээд түгээмэл бөгөөд шууд тусагдахууны референт тухайлсан, эс тухайлсныг ялгаатай зааж хэлбэржүүлдэг 300 орчим хэл байна⁶ гэсэн судалгааны баримт байна.

(6) *Багшаас монгол хэлний тайлбар толь аваад ир.*

(7) *Багшийн монгол хэлний тайлбар толийг аваад ир.*

Жишээ (6)-д монгол хэлний ямар толь бичиг байх нь өгүүлэгч болон сонсогчид тодорхой биш, зөвхөн монгол хэлний тайлбар толь гэдэг нэрийн зүйлд хамаарах толь бичгийг багшаас авах тухай байхад жишээ (7)-д “багшийн” гэдэг тодотгогчтой тул тодорхой нэг референт байгааг тодотгогчтой нэрийн бүлгийг заахын тийн ялгалаар хэлбэржүүлснээр шууд тусагдахууны онцлон ялгаж зааж байна. Өөрөөр хэлбэл багшид хамааралтай, түүний эзэмшлийн тодорхой нэгэн толь буйг мэдэх үед ийн хэлнэ.

(8) *Тэнхимд очоод багшаас монгол хэлний тайлбар толийг нь аваад ир.*

Тэнд тодорхой нэг монгол хэлний тайлбар толь байгаа, бид ямар монгол хэлний тайлбар толь болохыг мэдэх ч байж болно эсвэл хам сэдвийн хүрээнд энэ тухай гараагүй бол мэдэхгүй ч байж болно, харин багшийн номын санд байдаг, түүнээс гуйж авч болох толь бичгийн нэг гэдэг хүрээнд онцлон ялгасан жишээ (9)-г энэтхэг-европ хэлээр орчуулахад тодотгогчтой нэрийн бүлэг учир тухайлах ялгацтай хэлэх боломжтой, эсвэл багшид хамаадах учир хамаатуулах төлөөний нэрээр хэлэх боломжтой. Энэ өгүүлбэрийг тухайлах ялгацтай хэлсэн тохиолдол нь онцлон ялгах, тодорхойг заах хоёр нь хэлний нэг нэгжээр илэрч байгаа тул давхцаж байхад монгол хэлэнд заахын тийн ялгалын нөхцөл хэрэглэж байгаа нь ил илрэх арга болж байна.

Шууд тусагдахууныг дараах шаталсан байдлаар ялган заах боломжтой. Үүнд:

- | | |
|-------------------------------|---|
| i. тодорхой | Би (энэ, тэр) номыг уншсан. (Аль ном?) |
| ii. тодорхой бус, ялгасан | Би (нэг, нэгэн) ном уншсан. (Ямар ном?) |
| iii. тодорхой бус, үл ялгасан | Би ном уншсан. (Юу хийсэн бэ?) |

Испани⁷, орос хэл шууд тусагдахууны амьтай/амьгүйг онцлон ялгаж заадаг бол перс, түрк хэл тодорхой/тодорхой бусыг онцлон ялгаж заадаг байна.

Монгол хэлний нэгжийн утга, үүргийн судлалд нийт нэрийн бүлэгт тодорхойн айн илрэх байдлыг цогц байдлаар судласан зүйл хараахан үгүй боловч шууд тусагдахууны үүргээр орсон нэрийн бүлгийг онцлон ялгасан эсэхийг судлан тогтоожээ.

Орчин цагийн монгол хэлний заахын тийн ялгал (ЗГЯ)-ын нөхцөл “...-ийг (-ыг), -г хувилбараас гална хэлэхийн хэмнэл, үл ялгах ёсноос үүдэж бий болсон тэг хувилбартай”⁸.

6. Bossong 1985:256

7. Шууд тусагдахууны хэлзүйн аргаар илэрхийлсэний хамгийн түгээмэл жишээ бол амьтай болон тодорхойн заасан үед буюу бодгалийн шинж нь их байхад дагавар болон угтвар үгийн аргаар илэрхийлдэг.

a) Busco mi sombrero.

bi hajj baina minii malgai
'Би малгайгаа хайж байна'

b) Busco a mi amigo.

bi hajj baina P minii naiz
'Би найзыгаа хайж байна'

8. Ц. Өнөрбаян (ред.), 2010:138.

Б.Пүрэвсүрэн

Ялгах ёс нь өгүүлбэрт тусагдахуун гишүүн болж байгаа нэр үг болон нэрийн бүлэг

i. аливаа нэг зүйл оор бусад төрөл, зүйлийн юмнаас ялгаатай болох төдийг заах буюу жинхэнэ нэрийн ерөнхий утгаар онцлон ялгалгүй заах

ii. ижил төрөл, зүйлийн бусад юмнаас нь онцлон, ялгаж заахын эсрэгцлээр илэрдэг

болохыг академич Ш. Лувсанвандан 1953 онд “Монгол хэлний ялгах ба үл ялгахын ёсон” өгүүлэлдээ “...нэрийн зүйлийг өгүүлбэрт хэрэглэхдээ үгүүлэгч сонсогч этгээдийн сэтгэлд уул юмны нэр” онцгойрон ялгагдаж байгаа эсэх нь ЗТЯ-аар хэлбэржих нөхцөл болох тухай тэмдэглэжээ”.

Эл өгүүлэлд монгол хэлний зүйг судласан эрдэмтдийн бүтээлээс Алексей Бобровниковын 1849 онд хэвлүүлсэн “Монгол халимаг хэлний зүй”-дээ “онцлон ялгалгүй, өргөн утгыг хадгалж, үйл үгийнхээ хамтаар бүхэл төрөл үйлдлийг заасан нэрийг заахын тийн ялгалын дагаваргүйгээр үйл үгийн нь шууд өмнө тавина” гэснийг утга, үүргийн талаар тодруулан тайлбарлахын зэрэгцээ Б.Х. Тодаева “Орчин цагийн монгол хэлэнд заахын тийн ялгалын дагавартай хэрэглэх нь” өгүүлэлдээ “... үгүүлэхүүнээсээ үгүүлбэрийн бусад гишүүнээр зааглагдаж утгаараа нэлээд биеэ даагаад их төлөв утгын өргөлт тохиолдож байвал заахын тийн ялгалын дагавартай байна” гэсэн нь “монгол хэлний зүйд заахын тийн ялгалыг дагавартай, дагаваргүй хэрэглэх газрыг зүйлчлэн тодорхойлсон боловч яагаад гэдгийг тайлбарласангүй” гээд А. Бобровниковын санааг давтсанаас илүү шинэ зүйл нэмсэнгүй гэж үзсэн байна.

Л. Мишиг 1957 онд хэвлүүлсэн “Монгол хэлний тусагдахуун ба байц” номдоо ялгах ёсны тухай ажиглалт хийжээ. Тусагдахуун болж байгаа үг нь өргөн утгатай биш, нэг төрлийн ижил юмнааснь зориуд ялган зааж байгаа тодорхой утгатай үг байдаг тухай дэлгэрэнгүй тайлбарлажээ¹⁰. “Заахын тийн ялгалд байгаа үг шууд тусагдахуун болж үйл өгүүлэхүүнд захирагдахаас гадна гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн болж өгүүлэхүүнтэй харилцан зэрэгцсэн харьцаа заах өвөрмөц тохиолдол бий” гээд “Гишүүн өгүүлбэрийн заахын тийн ялгалаар хэлбэржсэн өгүүлэгдэхүүний үйл өгүүлэхүүн ихэвчлэн үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлөөр хэлбэржсэн байдаг” гээд

(9) *Дүүгээ явмагц би гэртээ буцаж ирсэн.*

(10) *Доржийг ажлаа дуустал би хүлээнэ.*

9. *Би таны унах морийг барилаа.*

Би хонинд унах морь барилаа.

Эхний өгүүлбэрт тодорхой нэг морийг бусад морьдоос ялгаж, онцолсон учир ЗТЯ-ын нөхцөлтэй байхад удаах жишээнд чухам ямар нас, зүсмийн морь болох нь уг өгүүлбэрийн чухалчлах санаа биш, ерөөс унаж эдлэх зорилгоор адуун сүргээсээ нэгэн морь барьсан гэдэг мэдээлэл гол учраас ЗТЯ-ын нөхцөлгүй байна. Академич Ш. Лувсанвандан ЗТЯ-ын нөхцөл утга ялгах ёс нь уг юм өгүүлэгч болон сонсогчийн аль нэгэнд танил бус, ярианд анх удаа дурдагдаж байгаагаас хамааралтай болох тухай

Би нэг морь авлаа.

Та тэр морийг үзнэ үү.

гэсэн өгүүлбэрээр тайлбарлахдаа ЗТЯ-ын нөхцөлгүй “морь” гэдэг нь үл ялгасан хэрэглээ бөгөөд үзүүлэх гэж буй “морь” харьцангуй тодорхой, худалдан авсан тухай өмнө нь дурдагдсан болохоороо ялгаатайг зааж байна гэжээ.

10. Олон тооны уран зохиолын жишээгээр оновчтой тайлбар хийсэн боловч 73-р талд “... хурим хийнэ гэж зочид урьчихаад...” гэхэд “зочид” гэдэг үгийг ЗТЯ-ын нөхцөлгүй хэрэглэснийг “найр наадам хийхээр олон хүнийг урих” гэсэн ерөнхий олныг заасан утгатай хэмээн тайлбарлаж болохыг анхааралгүй, найруулгын онцлогоос хамааралтай гэж үзжээ.

Б.Пүрэвсүрэн

гэх мэт жишээгээр ялгах ёс ХНӨ-ийн түвшинд илрэх¹¹ талаар ажиглалт, дүгнэлт хийснээрээ өмнөх бүтээлүүдээс дэлгэрэнгүй болсны зэрэгцээ тооны нэрийн зүйлээр илэрсэн тусагдахууны ЗТЯ-ын нөхцөл авахтай холбоотой сонирхолтой ажиглалт ийжээ.

Монгол хэлэнд тооны нэр “Өмнөх үгсийнхээ тоог багцлан зааж орсон¹² хоёр, гурав, хоёр, гурвуул гэх зэргийн тооны үгс бол заахын дагавартай байна” гээд

(11) *Хүн чоно хоёрыг ялгаж таньсангүй.* гэх мэт жишээ дурджээ.

Манай эрдэмтэд нэгэн жарны тэртээ шууд тусагдахууныш онцлог заах үзэгдлийг ажиглан судалж, монгол хэлний заахын тийн ялгалын нөхцөл болон түүний тэг хувилбарын эсрэгцэл нь “башкир хэлнээ категори определенности и неопределенности илрэх талаар Зөвлөлтийн эрдэмтдийн хийсэн ажиглалттай төстэй болох”-ыг Ш. Лувсанвандан тэмдэглэсэн бол Л. Мишиг “Түркийн олон хэлийг судалсан эрдэмтэд уйгар, башкир, кумык, түрк, ойрод зэрэг хэлэнд мөн ялгах, үл ялгахын ёсон бий” хэмээн тэмдэглэжээ.

Монгол хэлний бүтээврүүд нь тогтсон байр, нарийн дэс дараатай бөгөөд тэдгээрийн зааг нь тодорхой байна. Монгол хэлний бүтээврүүд нь язгуур-дагавар-нөхцөл гэсэн ерөнхий дараалалаар байрладаг болохыг нэр үгийн хувиллын бүтцээр үзүүлбэл:

язгуур – дагавар – тоо – тийн ялгал – хамаатуулах

гэсэн дараалалтай байна. Харин нэр үгийн үндсэнд залган орох тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцлийн аль нь ч тодорхойг заах бөгөөд эдгээр нөхцөл заавал угсарч орох бус зэрэгцсэн харьцаанд байна гэж үзэж болох талтай байна.

	тоо
язгуур – дагавар	тийн ялгал
	хамаатуулах

Монгол хэл ялгацгүй хэл учраас өмнө дурдсанчлан заахын тийн ялгалын нөхцлөөр илэрхийлэхээс гадна харьяалах болон хамаатуулах олон тоо заах үг болон үгийн сангийн бусад нэгжээр тодорхойн айг илэрхийлдэг болохыг лавлаж үзвэл үзвэл ялгах, үйл ялгах ёс, тодорхой тодорхой бусын айн монгол хэлэнд илрэх аргын талаар сонирхолтой зүйл их байна.

Хүн төрөлхтний хэл түгээмэл зүй тогтолтой болохыг судлах нь өнөөгийн хэл шинжлэлийн үндсэн чиглэл болоод байгаа билээ. Хэл бол хүний ертөнцийн юм, үзэгдлийг танин мэдэх, мэдээлэл авах, хадгалах, боловсруулах, дамжуулахтай холбоотой оюуны үйл бөгөөд хэл ярианы

11. Д.Гүнцэцэг, 2009:9.

12. Б. Пүрэв-Очир, 1993:55-74. Хоёр, гурав гэж багцлан заасан зүйл нь тухайлсан байдаг тухай "... зэрэгшлийн эгнээг "хоёр" гэдэг үгээр гаднаас нь хааж ... зэрэгшлийн эгнээ нь ямагт хоёр элементтэй олонлог байх бөгөөд үүнийг "хоёр юмыг тухайлах утга" гэж нэрлэж болмоор" гээд "Өвгөн, шувуу хоёр" "Лав, ээж хоёр" "Алтай, Хангай хоёр", "Алт, мөнгө хоёр", "Гэсэр, Жангар хоёр", "Газар, хүн хоёр", "Өвгөн, тэнгис хоёр", "Хулан, Цамба хоёр", "Кирилл, Мефодий хоёр" гэх зэргээр хэрэв "гурав" гэдэг үгээр хаан холбож, "төлөи, гуулай, чоно гурав" гэвэл гурван л юмыг тухайлж өгүүлэх, цааш нь өөр юмыг тоочих, өгүүлэх утгагүй болно гэжээ. Монгол хэлэнд тооны үгээр зэрэгцсэн үг, гишүүнийг гаднаас холбон, хааж хэрэглэдэг ёс нь хэлзүйн найруулгын өвөрмөц арга хэмээн тайлбарлажээ. Монгол хэлний найруулгад ийнхүү хоёр, гурав, дөрөв гэх мэт тооны үгээр холбож, хаахал цааш нь тоочих гэсэн санаа, ерөнхийлж товчлох байдал; ... гэх зэрэг; ... гэх мэт; ... нарын зэрэг; ... зэрэг гэсэн нэмэлт мэдээлэл, хамтатгах харьцаа илэрдэггүй. Зэрэгцэлд авч тоочих, нэрлэх л ёстой тус бүр нэг, бүгд хоёр, гурван зүйлээ л нэрлэсэн байдаг зүй тогтол байна. Хэлний баримтыг шинжилж үзэхэд, зэрэгшлийн эгнээнд орсон нэр үг тус бүр нь ямагт ганц тоонд байж, тооны нөхцлийнх нь дараа залгаж орох ёстой нэрийн тийн ялгалын нөхцөл нь "хоёр" гэдэг үгийнхээ ард нь байрлаж сая харьцааны утга илтгэдэг зүй тогтолтой ажээ" хэмээснийг хоёр, гурав гэсэн тооны нэр нь нэрийн бүлгийг тодорхой, ялгасан утгатай зааж байгаатай холбоотой болохыг нягтлан үзүүштэй.

Б.Пүрэвсүрэн

явцад хуримтлуулсан туршлагыг эмх цэгцэд оруулах үйлдэл нь нийт хүн төрөлхтөнд нийтлэг үндсэн зарчимтай болохыг улам бүр баталсаар байна. Тиймээс тодорхой хэлний өвөрмөц онцлог байхын сацуу хэл бүрт түгээмэл зарчим, дүрэм ажиглагдаж байдаг. Үүний нэг нь бидний энэ удаагийн судлахуун болох нэрийн бүлгийн тодорхой/тодорхой бусын ай бөгөөд хэл, хэлэхүйд нэрийн бүлгийг онцлон ялгаж, тухайлан тодорхой илэрхийлэхийн зэрэгцээ эс тухайлан хэлэх нь нийт хүн төрөлхтний хэлний түгээмэл үзэгдэл болдог байна.

Нийт хэлний түгээмэл, тодорхой хэлний өвөрмөц онцлогийг тогтоох зорилт нь бидний ухамсарт байгаа мэдлэг хэлзүйн үзэгдлийн мөн чанарыг нээх, тодорхойлоход чухал үүрэгтэй. Нэрийн бүлгийг тухайлах, эс тухайлах арга, хэлбэр монгол хэлнээ хэрхэн илэрч байгааг дэлхийн бүх хэлэнд хэлзүйн нэгдсэн суурь гүний бүтэц байна үзэл баримтлалын үүднээс судлах шаардлагатай бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт нь монгол хэлийг гадны хүнд заах, монгол хүний гадаад хэл заах арга, аргачлалыг боловсруулахдаа хэлний үзэгдлийн утга, хэлбэрээр илрэх байдлыг анхаарах, гадаад хэлнээс монголчлох, харь хэлэнд хөрвүүлэх, хэлийг цахимд хөрвүүлэх зэрэг үйлийн хэл шинжлэлийн үндэслэлийг боловсруулахад ач холбогдолтой болно.

Б.Пүрэвсүрэн

НОМЗҮЙ

Лувсанвандан. Ш., Бүтээлийн чуулган, VIII боть, УБ., 2010.

Мишиг. Л., Монгол хэлний тусагдахуун ба байц, УБ, 1957.

Өнөрбаян. Ц., (ред.). Орчин цагийн монгол хэл, 2010.

Пүрэв-Очир. Б., Монгол хэлний зарим холбох үгийн утга, үүрэг. Монгол судлал №4 (25), 1993.

Равдан Э., Орчин цагийн хэл шинжлэл, УБ., 2005.

Croft, William. Typology and Universals. Cambridge University Press, 1990.

Givon, T., Syntax: A Functional Typological Introduction, Chicago, 1984.

Guntsetseg, Dolgor. Differential object marking in (Khalkha)-Mongolian, <http://www.ilg.uni-stuttgart.de/projekte/C2/publications/Guntsetseg.pdf>

Udo Klein, D. Guntsetseg, Klaus von Heusinger, Embedded Subjects in Mongolian, www.ilg.uni-stuttgart.de/projekte/C2/publications/C2_vonHeusingerKleinGuntsetseg_submitted.pdf

Lyons, Christopher. Definiteness, Cambridge: CUP, 1999. Hawkins, J.A., Definiteness and indefiniteness, London, Croom Helm, 1999.

Cross-linguistically it is common for definiteness to interact with the marking of case in certain syntactic contexts. In modern Mongolian language direct objects (DOs) receive distinctive marking only if they are specific